



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/33

Арвайхээр

Гамшгийн үед хүн амыг нүүлгэн
шилжүүлэх байршлыг тогтоох тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгийн үед сумын хүн, амыг нүүлгэн шилжүүлэх байршлыг Хүйс толгойн 11 дүгээр багийн нутаг дэвсгэр Ямаатын хонхорын зүүн дэнж нэртэй газар (1 цэг 102°51'42.700"E, 46°15'39.180"N, 2 цэг 102°51'37.349"E, 46°15'44.490"N, 3 цэг 102°51'46.917"E, 46°15'49.129"N, 4 цэг 102°51'52.268"E, 46°15'43.820"N) байхаар тогтоосугай.

2. Нүүлгэн шилжүүлэх байршлыг тавигдах шаардлагын дагуу тохижуулах тооцоо, судалгааг гаргаж сумын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгаж, иргэдэд сурталчлан таниулж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (С.Ганчимэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ГАНБАТ

371100065